

Тэнхимийн олон нийтийн үйл ажиллагаа



Хүрээ Мэдээлэл Холбоо Технологийн Дээд сургуулийн Хоолзүй, шим судлалын тэнхимийн багш оюутнууд Дорноговь аймгийн Айраг суманд 2023 оны 9.28 - 9.29-ны өдрүүдэд сайн дурын ажил зохион байгууллаа

- Нийгмийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах, орон нутгийн тусламж хэрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ЕБС-ийн 11-12-р ангийн сурагчдад хоол зүй шим тэжээлийн мэдлэг олгох зорилгоор орон нутагт ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цусан дахь сахар хэмжилт, цусны даралт хэмжилт, биеийн ерөнхий индекс хэмжигч төхөөрөмжөөр хийсэн хэмжилтэнд үндэслэн тэнцвэртэй хооллолтын зөвлөгөө, “Зөв хооллолт” сургалт мөн хоёр төрлийн хоол, хоёр төрлийн зууш хийхийг зааж хамтран хийлээ.
- ЕБС-ийн сурагчдад “Өсвөр үеийнхний зөв хооллолт” танхимын сургалт, биеийн ерөнхий индекс хэмжигч төхөөрөмжийн хэмжилтэнд үндэслэн хооллолтын зөвлөгөө болон архи, тамхины хор хөнөөлийн тухай мэдээлэл зөвлөгөө өглөө.

Хүрээ МХТДС-ын Хоолзүй, шим судлалын тэнхимийн мэргэжлийн клубын сайн дурын аян - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5р баг

Хоолзүй, шим судлалын 3-4р курсын оюутнуудыг хичээлээр үзсэн мэдлэгээ баталгаажуулах, шим тэжээлийн сургалт болон зөвлөгөө өгөх практик чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 5р сарын 10-ны өдөр насанд хүрэгчдэд биеийн дотоод үзүүлэлтүүдийн хэмжилт, зөвлөгөө, “Даралт зүрх судасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хооллох хэв маяг” сургалт, “Даралт зүрх судасны өвчлөлийн үеийн хоолны жор” танилцуулан зөвлөгөө өгч өсвөр насныханд “Өсвөр насны тэнцвэртэй хооллолт” сургалт болон биеийн дотоод үзүүлэлтүүдийн хэмжилтэн дээр суурилсан зөвлөгөө өгч ажиллалаа.



-
- Хүрээ МХТДС-ийн Хоолзүй, шим судлалын тэнхимийн оюутнууд УНДЭ дээр зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй дүүрэг” урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд сайн дурын ажилтнаар ажиллалаа



Цэцэрлэгийн эрхлэгч нарт
Солонгос хоолны соёл сургалт
зохион байгууллаа.
2023.10.13

- Хоолзүй, шим судлалын тэнхимийн эрхлэгч Пак Кён Хи Улаанбаатар хотын Баянгол дүүргийн цэцэрлэгийн эрхлэгч нарт Солонгос хоолны соёл сургалт, кимчи хийж сурах семинарыг тус сургуулийн Шим судлалын лабораторид амжилттай зохион байгууллаа.





Цэцэрлэгийн хүүхдийн “Зөв
хооллолт” сургалт зохион
байгууллаа

Оюутнуудыг хичээлээр үзсэн мэдлэгээ бататгах, чадавхижуулах зорилгоор БЗД-ийн 305-р цэцэрлэгт 2-5 настай хүүхдийн хооллолт сэдвээр цэцэрлэгийн хүүхдүүдэд сургалт орлоо.



ЕБС-ийн сурагчдад биеийн дотоод үзүүлэлт хэмжиж зөвлөгөө өгөх ажил зохион байгууллаа

- Оюутнуудыг хичээлээр үзсэн мэдлэгээ бататгах, чадавхижуулах зорилгоор Нийслэлийн 28р сургуулийн 5-р ангийн 60 сурагч, Хүрээ тулга сургуулийн 5-р ангийн 45 сурагчдад биеийн хэмжилтийг тусгай төхөөрөмжөөр хийж зөвлөгөө өглөө.